



Н.Н.Поппе. ДӨРВӨЛЖИН БИЧИГ.

Орос хэлнээс орчуулсан Х.Лувсанбалдан,
орчуулгыг хянасан Б.Түвшинтөгс. Уб., 2019. 130
х. ISBN 978-99978-985-9-3

Монголчууд бидний зохион хэрэглэж ирсэн үсгийн нэг нь Хубилай сэцэн хааны зарлигаар Пагва лам Лодойжалцан зохиосон дөрвөлжин бичиг билээ. Дөрвөлжин бичгээр монгол хэлнээс гадна түрэг, самгарди, төвөд, хятад зэрэг хэлээр бичсэн олон тооны дурсгал хадгалагдан ирсэн байдаг. Тэдгээр дотор дөрвөлжин бичгийн монгол дурсгал тооны хувьд 70 гаруй олдлоод байгаа бөгөөд дундад үеийн монгол хэлний баримт болохоос гадна Юань улсын төрийн бодлого, үйл ажиллагааг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж өгдөг. Иймд уг бичгийг судлах нь хэл бичгийн мэргэжилтэн төдийгүй түүх, соёл судлаачид ч мөн чухал хэрэгцээтэй юм. Энэхүү шаардлагын улмаас монголч эрдэмтэн Н.Н.Поппе “Квадратная

письменность” хэмээх бүтээл туурвиж 1941 онд хэвлүүлсэн нь өдгөө ч шинжлэх ухаанч чанараа алдаагүй хэвээр байгаа билээ. Иймд дөрвөлжин бичиг зохиосны 750 жилийн ойд зориулан Н.Н.Поппегийн тус бүтээлийн монгол орчуулгыг эрдэмтэн Х.Лувсанбалдангийн 1959 онд хийсэн орчуулгаар толилуулж байна.

Уг ном нь эрхлэн хэвлүүлэгчдийн бичсэн Өмнөх үг (х.III-VIII. Б.Түвшинтөгс), Оршил (х.1-2), Удиртгал (х.3-20), Дөрвөлжин бичгийн цагаан толгой (х.23-30), Дөрвөлжин бичгийн хэлний онцлог (х.33-47), Дөрвөлжин бичгийн дурсгалууд (х.51-103), Дөрвөлжин бичгийн монгол дурсгалын үгийн цэс (х.107-118), Номзүй (х.119-228) гэсэн бүтэцтэй бөгөөд мөн хавсралт, олон тооны зурагтай.

* * *



Ш.Лувсанвандан. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ЧУУЛГАН

XX зууны Монголын орчин үеийн хэл шинжлэлийн ухааны үүсэл, хөгжил, төлөвшилд тодорхой хувь нэмэр оруулсан эрдэмтэн бол Ш.Лувсанвандан (1910-1983) билээ. Тэрбээр 29 насандаа буюу 1939 онд “Монгол хэлний зүй” хэмээх бүтээл туурвисан нь монгол хэлийг Ром-Европын хэл шинжлэлийн онол, аргазүйн үүднээс монгол эрдэмтэн өөрөө судлан үзсэн анхны бүтээлийн нэг болсон юм. Ийнхүү орчин цагийн монгол хэл шинжлэлийн салбарын тулгын чулууг тавилцсан тэрбээр улмаар монгол хэлийг авиа, бүтээвэр, үг, өгүүлбэр, үгийн сан, нэр томъёо судлал зэрэг өргөн чиглэлээр судалж хэлний бүхий л түвшнийг хамарсан олон тооны бүтээл туурвилаараа монгол хэл шинжлэлийн салбарыг тогтолцоотой шинжлэх ухаан болон хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Академич Ш.Лувсанвандан эх хэлээ олон жил судалсны дүнд “Орчин цагийн монгол хэлний бүтэц” (Тэргүүн дэвтэр: авиа, авиалбар хоёр нь. 1967; Дэд дэвтэр: үг, нөхцөл хоёр нь. 1968) бүтээл туурвиж монгол хэлийг тогтолцоот бүтэц болохыг товчоолон гаргасан билээ. Түүний энэхүү судалгааны ажил угтаа монгол хэл шинжлэлд бүтэцзүйн аргыг тууштай нэвтрүүлсэн бүтээлд тооцогддог. Хэдийгээр сүүлийн үед хэл шинжлэлийн янз бүрийн чиг хандлага бидний судалгааны салбарт нэвтэрсээр буй боловч хэлийг бүтэц, тогтолцооных нь үүднээс авч үздэг хандлага өнөө ч тэргүүлэх чиглэл хэвээр байна.

Монгол хэлний бүхий л салбарыг хамарсан өргөн дэлгэр бүтээлээрээ орчин цагийн монгол хэл шинжлэлийн ухааны үүсэл, хөгжил, төлөвшлийг тодорхойлоход тэргүүлэн оролцсон академич Ш.Лувсанванданы эрдэм шинжилгээний

бүтээлийг Монгол судлалын үндэсний зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Монгол судлалын шилдэг өв” цувралаар хэвлэн нийтэллээ. Ингэхдээ зөвхөн бие даан туурвисан ном, өгүүллийг нь сонгон 6 ботид хэсэглэн оруулсан болно. Үүнд:

I боть – Монгол хэлний зүй. Энэхүү ботид “Лу багшийн цагаан ном” хэмээн олон нийтэд алдаршсан “Монгол хэлний зүй” (1939) бүтээлийг анх хэвлэгдсэн байдлаар нь болон англи орчуулгын гэрэл зургийн хамт хэвлэлээ.

II боть – Орчин цагийн монгол хэлний сурах бичиг. Энэ ботид академич Ш.Лувсанванданы монгол хэлний журамлах хэлзүйн зорилгоор туурвисан сурах бичгүүдийг хэвлэлээ.

III боть – Орчин цагийн монгол хэлний бүтэц. 1971 онд Монгол Улсын Төрийн шагнал хүртсэн “Орчин цагийн монгол хэлний бүтэц” (Тэргүүн дэвтэр: авиа, авиалбар хоёр нь. 1967; Дэд дэвтэр: үг, нөхцөл хоёр нь. 1968) бүтээлийг энэ ботид хэвлэлээ.

IV боть – Монгол хэлний авиа, үсэг бичгийн судалгаа. Академич Ш.Лувсанванданы авиазүй, үсэг бичиг судлал, нутгийн аялгууны судалгаатай холбогдох эрдэм шинжилгээний өгүүллүүдийг энэхүү ботид хэвлэлээ.

V боть – Монгол хэлний бүтээвэр, өгүүлбэр, үгийн сан судлал. Энэхүү ботид монгол хэлний бүтэц, тогтолцооны асуудал, үгсийг аймаглах зарчим, өгүүлбэрийн бүрэлдэхүүн, тэдгээрийн харилцааны талаар авч үзсэн өгүүллүүдийг хэвлэлээ.

VI боть – Ерөнхий хэл шинжлэлийн зарим асуудал ба орчуулга. Академич Ш.Лувсанвандан зөвхөн эх хэлээ судлаад зогсохгүй түүнийг ажиллаж бүтээж байх үед нь ид өрнөж байсан хэл шинжлэлийн

онолын маргаантай асуудлуудыг дорно дахины философийн үүднээс авч үзэн тайлбарласан бүтээлүүдийг энэ ботид эмхлэн хэвлэлээ. Мөн тэрбээр гадаадын судлаачид, тэдний бүтээл туурвилыг эх хэлээрээ танилцуулахад багагүй үүрэг гүйцэтгэснийг энэхүү ботид буй орчуулгын бүтээлүүдээс тодорхой харж болно. Түүнчлэн зохиогчийн зарим өгүүлэл англи, орос, япон, хятад хэлээр орчуулагдсаныг холбогдох ботиудад оруулсан ба ихэнх бүтээл нь монгол бичгээр хэвлэгдэн гарсныг энэ удаа түр орхисон болно. Хэрэв тийнхүү хэвлэгдсэнээр нь уншихыг хүсэгчид энэ цувралын I ботид доктор Э.Пүрэвжавын

бүртгэж хавсаргасан академич Ш.Лувсанванданы эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалтаас тодруулан үзнэ үү.

Эдгээр ботийг хэвлэлд бэлдэхдээ эрхлэн хэвлүүлэгч болон хариуцлагатай редакторууд анхны хэвлэлийн эхийг баримталсан бөгөөд тухайн үеийн хэвлэлийн техник, технологийн боломжгүйгээс болж буруу эсвэл дутуу тавьсан тэмдэг, тэмдэглэгээг нөхсөн ба зарим өгүүлийг холбогдох зураг сэлтээр баяжуулсан болно. Зөв бичихзүйн хувьд жигдлэхийн зэрэгцээ зохиогч найруулгын ялгамжаатай хэрэглэсэн үг, хэллэгийг тэр хэвээр байлгасныг анхааралдаа авна уу.

* * *